# ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ
# БАРААНЫ ТЭМДГИЙГ БҮРТГЭХ, УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТЭДГЭЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ, ЖУРМЫН ХАВСРАЛТУУДЫГ БАТЛАХ ТУХАЙ

2011 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 112

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.4, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4 дэх заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Барааны тэмдгийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журам", уг журмын хавсралтууд /БТ-01, БТ-02, БТ-03, БТ-04, БТ-05, БТ-06, БТ-07, БТ-08, БТ-09, БТ-10, БТ-11, БТ-12, БТ-13, БТ-14/-ыг тус тус хавсралтаар батлсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Оюуны өмчийн газрын даргын 2004 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан 16 дугаар тушаал, Оюуны өмчийн газрын даргын 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн “Мэдүүлгийн маягт шинэчлэн батлах тухай” 80 дугаар тушаалаар батлагдсан “Барааны тэмдгийн өргөдлийн маягт” /БТ-01/-ийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.ЧИНБАТ

Улсын бүртгэлд 2012 оны 1 дүгээр сарын
30-ны өдрийн 3309 дүгээрт бүртгэсэн.

/ОӨГ-ын 2015-11-03-ны 179 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон/